*Төлөөлөн удирдах зөвлөлийн*
*2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн*
*№15/03 тоот тогтоолын Хавсралт №4*

# "МИК ХОЛДИНГ" ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү бодлогын зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс /цаашид "ТУЗ" гэх/ баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл журмыг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекст нийцүүлэн тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү бодлогоор "МИК Холдинг" ХК /цаашид "Компани" гэх/-ийн өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчдад ногдол ашиг хуваарилах бодлого, ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах хэлбэрийг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.3. "Ногдол ашгийн бодлого" нь нийтэд ил тод байна. .

## Хоёр. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

2.1 Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилах бөгөөд нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

2.2 Компани нь Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг хуваарилна.

2.3 ТУЗ нь дараах тохиолдолд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргана. Үүнд:

- 2.3.1 Энэ бодлогын 2.2-т заасан нөхцөл бүрэн хангагдсан;
- 2.3.2 Компани ашигтай ажилласан бөгөөд компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан хөрөнгө оруулалт болон тусгай зориулалтын санд зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа;

## Гурав. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

3.1 Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтооно.

3.2 Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

3.3 Компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, компанийн ашигт ажиллагааны түвшин, чадавхийг дээшлүүлэх шаардлагын үүднээс ТУЗ-ийн шийдвэрээр тодорхой хугацаанд ногдол ашиг хуваарилахгүй байж болно.

3.4 Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.

3.5 Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.



Maralmaa-175-12/03/2018 10:23

## Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

4.1 Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.

4.2 Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх хугацааг заасан байх бөгөөд энэ хугацаандаа ногдол ашгийг олгох ёстой. Ногдол ашгийг хугацаанд бүрэн олгоогүй зэргээр хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл учруулсан, хохироосон нь нотлогдвол гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтанд сануулах, цалинг тодорхой хугацаагаар, тодорхой хувиар бууруулах, ажлаас халах зэрэг арга хэмжээг ТУЗ-ийн шийдвэрээр оногдуулна.

4.3 Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх захирал хариуцна.

4.4 Ногдол ашгийг олгох хэлбэр нь мөнгөн хөрөнгө, зах зээлд идэвхитэй арилжаалагддаг үнэт цаасны хэлбэртэй байх нь зохимжтой. Хувьцаа эзэмшигч дансны дугаараа албан ёсоор мэдэгдсэн нөхцөлд бэлэн бусаар шилжүүлж болно. Хувьцаа эзэмшигч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд эд хөрөнгийн хэлбэрээр олгож болно.

4.5 Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэх бөгөөд энэ үүргийг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

4.6 Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээний сан байгуулж болно. Сан байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

4.7 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дахь дансанд шилжүүлэх бодлого баримтлана.

4.8 "Ногдол ашгийн хуваарилалтын тайлан"-г Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14-т заасны дагуу ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчийн жилийн энгийн хурлаар өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

___оОо___



Maralmaa-175-12/03/2018 10:23